

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- ☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо

ТАЗ-ийн 2019 оны 03 тогтоол

Дагаж мөрдөх огноо

2026-01-14

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2026-01-14

Байгууллагын нэр

Боловсролын Судалгааны Үндэсний
Хүрээлэн

Нэгжийн нэр

Сургалт, монгол хэл, бичгийн төв

Албан тушаалын нэр

Сургалт хариуцсан эрдэм
шинжилгээний ажилтан

Албан тушаалын ангилал, зэрэглэл

ТҮШУ-3

Ажлын цаг

8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил

Багшийн хөгжлийн ордон

Хөдөлмөрийн нөхцөл

Хэвийн

Онцгой нөхцөл

I. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Боловсролын салбарт хэрэгжиж буй хууль, тогтоомж, бодлого шийдвэрийн талаар болон багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих олон улсын чиг хандлага, боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны хөгжлийн хэрэгцээний судалгаа шинжилгээ хийх, түүний үр дүнд үндэслэн бүх түвшний багшийн болон боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын чадавхыг дэмжих, багшийн мэргэжил дээшлүүлэх төрөлжсөн болон бусад захиалгат сургалт, хүрээлэнгээс зохион байгуулах олон улсын, бүсийн, үндэсний болон бүсийн түвшний сургалт, төгсөлтийн дараах сургалтыг менежментээр хангах

Албан тушаалын зорилт:

- Боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, бодлого, түүний хэрэгжилт, насанд хүрэгчдийн суралцахуйн онол, боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны хөгжлийг дэмжих менежментийн талаар судалгаа, шинжилгээ хийх, тэдгээрийн үр дүнд үндэслэн боловсролын хүрээлэнгээс зохион байгуулах боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны сургалтын талаар баримтлах бодлого, арга хэмжээний санал, боловсруулах, хэлэлцүүлэх, холбогдох зөвлөмж боловсруулах;
- Боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг

дэмжих менежментийн судалгааны чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүс, судлаачтай хамтран ажиллах, санал, зөвлөмжийг холбогдох талуудад хэлэлцүүлэх, хүрээлэнгээс зохион байгуулах сургалтыг зохицуулах, холбогдох зөвлөмж, санал боловсруулах; 3. Боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих төрөлжсөн сургалт, ахисан шатны сургалтыг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагатай хамтран зохион байгуулах, аймаг, нийслэлийн боловсролын газар болон багшийн хөгжлийг дэмжих бүсийн төвийн мэргэжилтнийг чадавхжуулах, олон улсын болон бүсийн, үндэсний түвшний сургалт зохион байгуулах ажлыг холбогдох нэгж, байгууллагатай хамтран зохион байгуулах; 4. Байгууллагын болон нэгжийн төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнг тайлагнах, эрдэм шинжилгээний ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөн чиглүүлэх, удирдах; 5. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.			
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр: Т ¹ , Г ² , Х ³ , Ш ⁴
Зорилт 1-ийн хүрээнд	– Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Боловсролын ерөнхий болон дагалдах хууль, Инновацийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг баримталж ажиллах; – Боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн хөгжилтэй холбоотой хууль тогтоомж, бодлого, түүний хэрэгжилт, насанд хүрэгчдийн суралцахуйн онол, боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны хөгжлийг дэмжих менежментийн талаар судалгаа, шинжилгээ хийх, санал, зөвлөмж боловсруулах; – Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад үндэсний хөтөлбөрүүдэд боловсролын бүх түвшний багшийн хөгжлийн талаар тусгасан бодлого, арга хэмжээний талаар судалгаа, шинжилгээ хийх; – Судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд үндэслэн хүрээлэнгээс зохион байгуулах боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны сургалтын менежментийн талаар	Хууль тогтоомж, бодлого, арга хэмжээний талаарх судалгааны тоо Боловсруулсан хувилбарт саналын тоо	Г

¹ Туслах

² Гүйцэтгэх

³ Хянах

⁴ Шийдвэрлэх

	санал, боловсруулах тодорхойлох, санал, зөвлөмж өгөх.		
Зорилт 2-ийн хүрээнд	– Боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны хөгжлийг дэмжих сургалтын менежментийн судалгааны чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүс, судлаачтай хамтран ажиллах, санал, зөвлөмжийг холбогдох талуудад хэлэлцүүлэх, – Нэгжид хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын явц, үр дүнг сурталчлах, нийтийн хүртээл болгох, судалгаа, шинжилгээний мэдээллийн сан үүсгэх – Судалгаа, шинжилгээний ажлын явц, үр дүнг сурталчлах, нийтийн хүртээл болгох, судалгаа, шинжилгээний мэдээллийн сан үүсгэх; – Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг сайжруулах, судалгаа, арга зүйн бүтээлийн чанарт ахиц гаргах; – Эрдэм шинжилгээний бүтээлээ хэвлэн нийтлэх, хүрээлэнгийн болон нэгжийн судалгааны хүрээнд эрдэм шинжилгээний бичиг, мэдээлэл (бюллетень), сэтгүүл, сонин зэрэгт бүтээлээ нийтлүүлэх; – Үндэсний болон олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал, симпозиумд оролцох, илтгэл танилцуулга хийх; – Судалгааны ажлын үр дүнгийн талаар боловсролын сургалтын байгууллага, төрийн бус байгууллага, олон нийтэд үнэн зөв бодитой мэдээлэх; – Эрдэм шинжилгээний ном, өгүүлэл, хөтөлбөр, гарын авлагыг олон нийтийн мэдээлэл (вэб сайт, телевиз, радио, өдөр тутмын сонин гэх мэт)-ийн хэрэгслээр бодлого, төлөвлөгөөтэй сурталчлах.	Судалгааны ажлын тоо Хэвлэн нийтлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээлийн тоо Боловсруулсан зөвлөмж, сургалт, судалгааны үр дүнг хүртэгчдийн тоо Зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийн тоо, үр дүн	Г
Зорилт 3-ын хүрээнд	– Хүрээлэнгээс зохион байгуулах олон улсын болон бүсийн, үндэсний түвшний сургалт зохион байгуулах дазааныг боловсруулж, захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэх, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх; – Олон улсын болон бүсийн, үндэсний түвшний сургалтын талаарх мэдээллийг холбогдох талуудад танилцуулж хэлэлцүүлэх, санал авч менежментийг сайжруулах – Багшийн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээний судалгаа, захиалгад	Судалгааны ажлын тоо Төрөлжсөн болон ахисан шатны сургалтад хамрагдсан багш, ажилтан, мэргэжилтний тоо	Г

	суурилан хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих төрөлжсөн болон ахисан шатны сургалтыг аймаг, нийслэлийн боловсролын газар, багшийн хөгжлийг дэмжих бүсийн/үндэсний төвтэй хамтран зохион байгуулах - Аймаг, нийслэлийн боловсролын газар болон багшийн хөгжлийг дэмжих бүсийн төвийн мэргэжилтнийг чадавхжуулах ажлыг үе шаттай зохион байгуулж, үр дүнг тооцох; - Олон улсын болон бүсийн, үндэсний түвшинд зохион байгуулах сургалт, хэлэлцүүлэг, төгсөлтийн дараах сургалт зохион байгуулах ажлыг удирдах.	Олон улсын, бүсийн үндэсний түвшинд зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлгийн тоо, хүрсэн үр дүн	
Зорилт 4-ийн хүрээнд	- Хүрээлэнгийн болон Сургалт, монгол хэл, бичгийн төвийн урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад хамтран ажиллах, нэгжид хамаарах үр дүнг тайлагнах; - Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, заавар боловсруулах, хэрэгжилтийг хангах, төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнг тайлагнах, шийдвэр гаргахад оролцох; - Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллах; - Мэргэжлийн ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх, мэргэжил, мэргэшлийг дээшлүүлэх, арга зүйн бүтээлийн чанарт ахиц гаргах; - Ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, судлаачидтай хамтран ажиллах, хамтарсан судалгаа, хөгжүүлэлтийн ажил хийх.	Байгууллагын стратеги төлөвлөгөөний биелэлтийн хувь Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь, хагас жил/жилийн эцсээр Хамтарсан судалгааны ажил, үр дүн	Г
Зорилт 5-ийн хүрээнд	- Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэх, мэдээлэл судалгааг шуурхай, чанартай гаргаж өгөх; - Хуульд заасан чиг үүрэгт хамаарах асуудлаар холбогдох хуулийн дагуу байгууллага, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангаж, тэднээс ирүүлсэн албан бичиг, санал хүсэлтийг судалж барагдуулах; - Эрдэм шинжилгээ, судалгааны болон боловсролын байгууллага, иргэдтэй чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээлэл өгөх;	Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын гүйцэтгэл, чанар Мэдээлэл, зөвлөгөөний тоо	Г

	– Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баримтлан ажиллах; – Байгууллагын дүрэм, дотоод журмын мөрдөх, хамт олны үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг сахиж, ажлын хариуцлага, үг хэллэг, харилцаа, хандлагаар үлгэрлэн манлайлах.	Авлигын эрсдэлийн үнэлгээний үр дүн Байгууллагын болон нэгжийн удирдлага, хамт олны үнэлгээ	
--	--	---	--

II. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Магистраас доошгүй боловсролын зэрэгтэй
Мэргэжил	Боловсролын шинжлэх ухаан /0111/, Багш, мэргэжлийн /0114/, Менежмент ба удирдахуй /0413/
Мэргэшил	Эрдэм шинжилгээний дадлагажигч болон дэд ажилтны зэрэг дэвтэй
Туршлага	Боловсролын салбарт 8-аас доошгүй жил, үүнээс тухайн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны 3-аас доошгүй жил ажилласан.
Ур чадвар	• Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх ур чадвартай; • Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих талаар мэдлэг чадвартай; • Боловсролын болон хэл шинжлэлийн судалгааны арга зүй, тоон болон чанарын өгөгдөл мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх ур чадвартай; • Судалгааны програм хангамжийг ашигладаг, хэрэглээний програмуудыг эзэмшсэн байх; • Өгөгдлийн шинжилгээ хийх ур чадвар; • Гадаад хэлээр эрдэм шинжилгээний бүтээл боловсруулах, харилцах, эх сурвалж ашиглах дундаас доошгүй түвшний ур чадвартай; • Багийг удирдах, манлайлах, багаар ажиллах ур чадвартай; • Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг байх.

III. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр	1. Захирал 2. ЭНБД 3. Төвийн эрхлэгч
Албан тушаалд шууд харьяалуулан удирдуулах албан тушаалын нэр, тоо	
Бусад харилцах субъект	1. Бүх түвшний боловсролын байгууллагууд 2. Багш, эрдэмтэн судлаачид, мэргэжилтэн 3. Төрийн бус байгууллагууд 4. Эцэг эх, асран хамгаалагчид, хүүхэд

IV. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	
<u>Хүний нөөц, хууль, эрх зүйн асуудал хариуцсан ажилтан</u> <i>О.Оюунтунгалаг</i> О.Оюунтунгалаг (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20 26 ны 01 дугаар сарын 14 ний өдөр	
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
<u>Байгууллагын нэр:</u> Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн <u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u> (тамга/тэмдэг) <i>П.Оюунаа</i> П.ОЮУНАА (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20 26 ны 1 дугаар сарын 19 ны өдөр	